



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/113/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2020 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежер түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetsteg.e@audit.gov.mn

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70503020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	17



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2020.02.13 № 1-6/61

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2.1. Оршил

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Албаны дарга, цагдаагийн дэд хурандаа Ш.Цолмон танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-оос 2020 оны 01 дүгээр сарын 29-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 30-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Уранбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13ж/21 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь “Шүүхийн шинжилгээ явуулах эрх зүйн боловсронгуй орчин, оновчтой зохион байгуулалт, баталгаатай арга зүй, техник-технологийн дэвшлийг бүрэн ашиглах нөхцөлийг бий болгон, хүний нөөцийн чадварлаг баг бүрдүүлснээр аливаа хэргийг шинжлэх ухаанч нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино”.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Шүүхийн шинжилгээний албаны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шүүхийн шинжилгээний алба нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Шүүхийн шинжилгээний албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Шүүхийн шинжилгээний албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 145394.5 мянган төгрөгөөс тооцон 2907.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 4140.9 мянган төгрөгөөр тооцсон нь аудитын төлөвлөлтийн үе шатанд 2 хувиар тооцсоныг өөрчлөөгүй холбоотой болно. /шалтгааныг бичих/

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8696.4 мянган төгрөгөөр буюу 6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	965.1	47.8	-917.3
Урьдчилгаа			
Бараа материал	3861.4	918.4	-2943
Үндсэн хөрөнгө	119807.7	114971.6	-4836.1
Нийт хөрөнгө	124634.2	115937.8	-8696.4
Өр төлбөр	1132.0		-1132.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	123502.2	115937.8	-7564.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	123502.2	115937.8	-7564.4

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актын дүнгээр авлага үүсгэн хэрэгжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь тухайн жилийн зарцуулах бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө нь дүн өссөн нь 1178.0 мянган төгрөгийн ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор проектор худалдаж авсантай холбоотой байна.

Өр төлбөрийн дансны өглөг 1132.0 мянган төгрөгийн өр тус албанд 2017-2018 онд үүссэнийг 2019 оны 2,3 сард барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 115937.8 мянган төгрөг болж 7564.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Шүүхийн шинжилгээний албаны тайлант онд 195906.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 196800.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	187406.9	187406.9	-	100
Үндсэн үйл ажиллагааны орлого	8500.0	9394.0	894.0	110.5
Нийт дүн	195906.9	196800.9	894.0	100.5

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 195906.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 194982.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 194982.0 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь батлагдсан төсвийн төлөвлөсний дагуу зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны орлогын давсан давсан 2679.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэн, зарцуулах эрх үүссэнээр зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 3106.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2463.7 мянган төгрөгийн зөрчилд 3 акт тогтоож, 546.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 2559.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2559.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүллээ. Үүнд:

2.11.1 Зардлын данстай холбоотой асуудал

Аудитаар 2019 оны 1-12 сарын албан томилолттой үеийн цалингийн тооцооллыг үзэхэд 16 ажилтанд хоолны мөнгийг бүрэн тооцож олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль. Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох тухай журам"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчилд тооцсон дүнгээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2.11.2 Зардлын данстай холбоотой асуудал

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар нийт 3 ажилтанд илүү цалин тооцож олгосон.

Энэ нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчилд тооцсон дүнгээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2.11.3 Зардлын данстай холбоотой асуудал

Гарын хээний санч Б.Баттүшигт ШШҮХ-ийн захирлын 2019/10/07-ны өдрийн Б/401 тушаалаар ажил хавсарсны нэмэгдлийг ТТ-6-1 шатлалын 20 хувиар цалинжуулахаар заасан байтал үндсэн цалингийн 20 хувиар тооцон цалинг олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно" ШШҮХ-ийн захирлын 2019 оны Б/401 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчилд тооцсон зөрүүгээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Аудитаар илэрсэн 546.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Шүүхийн шинжилгээний албаны Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 15 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 965.1 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосноос бүрэн барагдуулсан байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллагад санхүүгийн Acoluos, цалингийн тооцооллын Payroll программууд ашиглагдаж байгаа ба эдгээр биет бус хөрөнгийг бүртгэлд тусгаагүй ашиглаж байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлтийн дансны заавар”-ын 4.48-д “Биет бус хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Хөрөнгийг бүртгэлд тусгаагүйгээс хөрөнгө эзэнгүйдэх, алдагдах эрсдэлийг бий болгож байна.

1.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программыг байгууллагын биет бус хөрөнгийн холбогдох анхан шатны баримтад үндэслэн данс бүртгэлд тусгах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Нягтлан бодогч 2018 онд ажил хүлээн авахад тус биет бус хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байсан гэсэн тайлбарыг өгч байна.

2. Зардлын холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байрны түрээсийн зардлаас 53000 төгрөгөөр принтерийн хор худалдаж авсан. Үндсэн цалингийн зардлаас 493500 төгрөгийн албан томилолтын зардалд зарцуулсан. Энэ нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ыг тус тус зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан алдаа тайлагнах, батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

2.3. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, батлагдсан төсвийн хүрээнд эдийн засгийн ангиллаар зарцуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ДАНС	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,826,507.00	966,155.00
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
3121	Төгрөг	0.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	0.00
33	АВЛАГА	965,147.00	47,795.00
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	965,147.00	-
335	Бусад авлага	-	47,795.00
3351	Байгууллагаас авах авлага	-	47,795.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,861,360.00	918,360.00
351	Түүхий эд материал	730,500.00	512,500.00
35130	Эм боох материал	730,500.00	512,500.00
354	Хангамжийн материал	3,130,860.00	405,860.00
35410	Бичиг хэргийн материал	399,000.00	-
35420	Аж ахуйн материал	1,506,000.00	380,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	480,000.00	-
35440	Түлш шатах тослох материал	720,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	25,860.00	25,860.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	119,807,697.84	114,971,644.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	119,807,697.84	114,971,644.04
392	Биет хөрөнгө	76,671,697.84	71,835,644.04
39201	Барилга, байгууламж	56,561,820.00	56,561,820.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,012,647.84)
39203	Авто тээврийн хэрэгсэл	19,800,000.00	19,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(19,250,000.00)	(19,800,000.00)
39205	Машин, тоног төхөөрөмж	53,413,891.24	55,193,891.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,482,199.24)	(39,876,858.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,531,832.89	6,531,832.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,903,647.05)	(5,562,393.33)
393	Биет бус хөрөнгө	43,136,000.00	43,136,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	43,136,000.00	43,136,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	124,634,204.84	115,937,799.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,132,009.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,132,009.00	0.00
413	Өглөг	1,132,009.00	0.00
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	1,132,009.00	-
4136	Бусад өглөг	0.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	123,502,195.84	115,937,799.04
51	Засгийн газрын хувь оролцоо	123,502,195.84	115,937,799.04
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	80,638,053.00	80,638,053.00
51101	Өмч: -Төрийн өмч	80,638,053.00	80,638,053.00
512	Хуримтлагдсан үр дүн	37,020,180.36	29,455,783.56
51210	Өмнөх үеийн үр дүн	37,020,180.36	37,020,180.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	(7,564,396.80)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,843,962.48	5,843,962.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	124,634,204.84	115,937,799.04

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	235,339,593.00	199,479,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,018,650.00	9,394,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	42,018,650.00	9,394,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	42,018,650.00	9,394,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,577,600.00	9,394,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,441,050.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	193,320,943.00	190,085,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	186,834,100.00	187,406,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	186,834,100.00	187,406,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,486,843.00	2,679,000.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	6,486,843.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,679,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	213,590,786.14	207,044,296.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	213,590,786.14	207,044,296.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	208,990,060.69	205,225,399.80
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	149,068,284.00	151,919,794.00
210101	Цалин	106,610,073.00	91,878,675.00
210102	Нэмэгдэл цалин	31,159,118.00	47,147,089.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,299,093.00	12,894,030.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,105,548.55	3,997,254.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	1,607,867.00	1,026,870.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	106,412.00	-
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	70,176.00	-
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	30,353.00	-
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,290,740.55	2,970,384.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,778,771.00	13,185,576.00
210301	Гэрэл цахилгааны зардал	428,691.00	763,452.00
210302	Түлш, халаалтын зардал	3,320,000.00	3,949,024.00
210304	Байрны түрээс	8,030,080.00	8,473,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,143,053.00	15,190,882.00
210401	Бичиг хэргийн материал	1,284,478.00	1,968,650.00
210402	Тээвэр, шатахууны зардал	8,155,610.00	10,020,000.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	1,599,965.00	1,602,232.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	581,500.00	703,950.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	521,500.00	896,050.00
2105	Нормативт зардал	4,531,000.00	4,529,500.00
210501	Эм	2,759,000.00	4,529,500.00
210502	Хоол	1,772,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,786,363.00	3,578,800.00
210602	Тавилга	-	40,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	532,000.00	1,327,800.00
210604	Урсгал засвар	13,254,363.00	2,211,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,323,450.00	5,493,500.00
210702	Дотоод томилолтын зардал	4,323,450.00	5,493,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,459,600.00	714,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,199,600.00	164,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	150,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	70,040.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	-	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,793,991.14	6,616,053.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,793,991.14	6,616,053.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,600,725.45	1,818,897.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,600,725.45	1,818,897.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,600,725.45	1,818,897.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	21,748,806.86	(7,564,396.80)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	21,748,806.86	(7,564,396.80)

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	203,898,543.00	199,479,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,577,600.00	9,394,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,577,600.00	9,394,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,577,600.00	9,394,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,577,600.00	9,394,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	193,320,943.00	190,085,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	186,834,100.00	187,406,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	186,834,100.00	187,406,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,486,843.00	2,679,000.00
131103	ЗГНХ, ЭДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	6,486,843.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,679,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	203,898,543.00	197,955,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	203,898,543.00	197,955,900.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	199,297,817.55	196,137,003.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	148,937,543.85	152,499,451.00
210101	Үндсэн цалин	84,899,544.00	88,671,855.00
210102	Нэмэгдэл	47,249,999.85	48,563,596.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,788,000.00	15,264,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,844,426.70	4,125,754.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	2,045,499.00	1,364,777.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	106,412.00	-
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	70,176.00	-
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	30,353.00	-
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,591,986.70	2,760,977.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	11,778,771.00	13,238,576.00
210301	Гэрэл цахилгааны зардал	428,691.00	763,452.00
210302	Түлш, халаалтын зардал	3,320,000.00	3,949,024.00
210304	Байрны түрээс	8,030,080.00	8,526,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,627,853.00	13,968,882.00
210401	Бичиг хэрэг	1,399,978.00	1,400,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,999,510.00	9,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,599,965.00	1,598,882.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	703,100.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	925,300.00	870,000.00
2105	Нормативт зардал	4,034,500.00	3,999,300.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,499,500.00	3,999,300.00
210502	Хоол, хүнс	1,535,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,799,673.00	1,955,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	799,600.00	800,000.00
210604	Урсгал засвар	8,000,073.00	1,155,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,785,450.00	5,000,000.00
210702	Дотоод албан томилолт	4,785,450.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,489,600.00	1,350,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,229,600.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	70,040.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	-	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,600,725.45	1,818,897.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,600,725.45	1,818,897.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,600,725.45	1,818,897.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	1,780,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	1,780,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,780,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,780,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,780,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(1,780,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	ДАНС	511.00	51,300.00		
C02	2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	37,502,053.00	3,361.02	13,961,599.19	51,467,013.21
C03	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C04	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,502,053.00	3,361.02	13,961,599.19	51,467,013.21
C05	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C06	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
C07	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
C08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	9,910,683.47	9,910,683.47
D01	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	80,638,053.00	5,843,962.48	37,020,180.36	123,502,195.84
D02	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	80,638,053.00	5,843,962.48	37,020,180.36	123,502,195.84
D03	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D04	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,638,053.00	5,843,962.48	37,020,180.36	123,502,195.84
D05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D07	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
D08	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D09	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(7,564,396.80)	(7,564,396.80)
18	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	80,638,053.00	5,843,962.48	29,455,783.56	115,937,799.04

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/					
ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	195,906,900.00	194,982,003.00	924,897.00	99.53
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	195,906,900.00	194,982,003.00	924,897.00	99.53
210	Бараа, үйлчилгээний зардал	195,906,900.00	194,982,003.00	924,897.00	99.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	152,631,200.00	152,499,451.00	131,749.00	99.91
210101	Үндсэн цалин	88,803,200.00	88,671,855.00	131,345.00	99.85
210102	Нэмэгдэл	48,564,000.00	48,563,596.00	404.00	100.00
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	15,264,000.00	15,264,000.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,885,700.00	4,125,754.00	759,946.00	84.45
210201	Тэтгэврийн даатгал	1,800,000.00	1,364,777.00	435,223.00	75.82
210202	Тэтгэмжийн даатгал	200,000.00	-	200,000.00	-
210203	ҮОМШӨ ний даатгал	250,000.00	-	250,000.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	50,000.00	-	50,000.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	2,585,700.00	2,760,977.00	(175,277.00)	106.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,250,000.00	13,238,576.00	11,424.00	99.91
210301	Гэрэл цахилгаан	850,000.00	763,452.00	86,548.00	89.82
210302	Түлш, халаалт	3,500,000.00	3,949,024.00	(449,024.00)	112.83
210304	Байрны түрээс	8,900,000.00	8,526,100.00	373,900.00	95.80
2104	Хангамж, бараа материалын зардал	13,970,000.00	13,968,882.00	1,118.00	99.99
210401	Бичиг хэрэг	1,400,000.00	1,400,000.00	-	100.00
210402	Тээвэр (шатахуун)	9,300,000.00	9,300,000.00	-	100.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,600,000.00	1,598,882.00	1,118.00	99.93
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	800,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	870,000.00	870,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	4,000,000.00	3,999,300.00	700.00	99.98
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,000,000.00	3,999,300.00	700.00	99.98
2106	Эд хогшил худалдан авах	800,000.00	800,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	800,000.00	800,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,370,000.00	1,350,040.00	19,960.00	98.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800,000.00	800,000.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	160,000.00	160,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	70,040.00	19,960.00	77.82
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	20,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	195,906,900.00	196,800,900.00	(894,000.00)	100.46
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	187,406,900.00	187,406,900.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	187,406,900.00	187,406,900.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,500,000.00	9,394,000.00	(894,000.00)	110.52
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,500,000.00	9,394,000.00	(894,000.00)	110.52
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	12.00	12.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан				

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	2,679,000.00	(2,679,000.00)	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	2,679,000.00	(2,679,000.00)	-
210	Бараа, үйлчилгээний зардал	-	2,679,000.00	(2,679,000.00)	-
2106	Эд хогшил худалдан авах	-	2,679,000.00	(2,679,000.00)	-
210604	Урсгал засвар	-	2,679,000.00	(2,679,000.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	2,679,000.00	(2,679,000.00)	100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,679,000.00	(2,679,000.00)	100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,679,000.00	(2,679,000.00)	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО				
620001	Удирдах ажилтан				
620002	Гүйцэтгэх ажилтан				
620003	Үйлчлэх ажилтан				